Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын
даргын 2023 оны 98 тоот тушаалын
6 дугаар хавсралт

Мэргэжлийн болон сургуулийн өмнөх боловсролын байгууллагын хяналт шинжилгээ, үнэлгээ хариуцсан ахлах мэргэжилтэн, Д Батдорж

# 2025 ОНЫ ХАГАС ЖИЛ-Н ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

## НЭГ. ГҮЙЦЭТГЭЛИЙН ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭНИЙ БИЕЛЭЛТ

| № | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Гүйцэтгэлийн түвшин | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин / биелэлт | Эхэлсэн, дууссан хугаца | Биелэлтийн хувь |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| 1.1. Урт болон богино хугацааны бодлогын баримт бичиг, төсөл, хөтөлбөр, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн болон үйл ажиллагааны төлөвлөлт, хэрэгжилт, тайлагналт, архив, албан хэрэг хөтлөлт, дотоод үйл ажиллагааны тасралтгүй байдлыг хангах, байгууллагын соёлыг төлөвшүүлнэ. | | | | | | | |
| 1 | Яамны болон салбарын мэдээллийн ил тод байдлыг ханган ажиллана. | Мэдээллийн тоо | 2024 оруулсан мэдээллийн тоо | Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын тайлан дүгнэлтийн талаарх мэдээллийг оруулсан байна. | Салбарын Ил тод байдлын шалгуур үзүүлэлтийн хэрэгжилт 2024 оны жилийн эцсийн байдлаар нийт 46 арга хэмжээний хэрэгжилтийн тайланд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж тайлагналаа. Боловсролын яамны ил тод байдлын шалгуур үзүүлэлт 100%-тай үнэлэгдсэн. Яамны болон салбарын мэдээллийн ил тод байдалд тогтмол хяналт тавьж, нэгжийн зүгээс холбогдох тайлан | 1-р сар, 6-р сар, 11-р сар | Өөрийн үнэлгээ: 100%<br>Нэгжийн даргын үнэлгээ: 100%<br>Нэгжийн даргын үнэлгээ төлөвлөсөн хугацаандаа гүйцэтгэсэн байдал: 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | мэдээг цахим хуудаст байршуулан ажиллаж байна. | | |
| 2 | Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн биелэлтэд хагас, бүтэн жилээр хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж тайлагнах. | Хууль, тогтоомж, тогтоол шийдвэрийн тоо | Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн биелэлтэд 2024 оны хагас, бүтэн жилд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний тайлан | Хяналт-шинжилгээ, үнэлгээний тайлангийн үр дүнгээр гарсан зөвлөмжийн биелэлтийг хангуулж ажилласан байна. | Боловсролын салбарын хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн 2025 оны 1-р сарын хэрэгжилтийн тайланд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж 2025 оны 02 сарын 10-ны өдөр Засгийн газрын үнэлгээний цахим системд тайлагнаж ажиллаа. Хэрэгжилт гаргах нийт заалтын тоо 266 Бүрэн хэрэгжсэн 100%-тай 198, Хэрэгжих шатанд 70%-тай 55, Хэрэгжилт хангалтгүй 30%-тай 4, Хэрэгжилтийг тооцох хугацаа болоогүй Х.Б-9 заалт тус тус үнэлэгдэж, Хэрэгжилтийн дундаж 92.41%-тай гарлаа. Боловсролын салбарын хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн 2025 оны эхний улирлын хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж 2025 оны 04 сарын 11-ний өдөр Засгийн газрын үнэлгээний цахим системд тайлагнаж ажиллаа. Хэрэгжилт гаргах нийт заалтын тоо 232 Бүрэн | 1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар | Өөрийн үнэлгээ: 100%<br>Нэгжийн даргын үнэлгээ: 100%<br>Нэгжийн даргын үнэлгээ төлөвлөсөн хугацаандаа гүйцэтгэсэн байдал: 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | хэрэгжсэн 100%-тай 167, Хэрэгжих шатанд 70%-тай 51, Хэрэгжилт хангалтгүй 30%-тай 2, Хэрэгжилтийг тооцох хугацаа болоогүй Х.Б-12, Хэрэгжилтийн дундаж 92.41%-тай үнэлэгдсэн. Мөн Засгийн газрын тогтоол шийдвэр, Ерөнхий сайдаас өгсөн үүрэг даалгаврын биелэлтээс 2024 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар хангалтгүй үнэлгээ авсан 21 заалтын хэрэгжилтийг 2025 оны 1 дүгээр улирлын байдлаар гарган Засгийн газрын ХШҮ-ний мэдээллийн цахим системд хугацаанд нь тайлагнаж ажилласан.<br>Хавсралт: 3 файл | | |
| 3 | Яамны гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж тайлагнах. /Хавсралт тайлангууд/ | Арга хэмжээний тоо болон хэрэгжилтийн хувь | Яамны гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн 2024 оны хагас, бүтэн жилийн тайлан | Хяналт-шинжилгээ, үнэлгээний тайлангийн үр дүнгээр гарсан зөвлөмжийн биелэлтийг хангуулж ажилласан байна | Боловсролын яамны гүйцэтгэлийн төлөвлөгөөний 2024 оны жилийн эцсийн биелэлтийн тайланд хяналт шинжилгээ, үнэлгээ хийж, засгийн газрын үнэлгээний цахим системд 2025 оны 02 сарын 28-ны өдөр оруулж баталгаажуулсан. Нийт | 2-р сар, 6-р сар | Өөрийн үнэлгээ: 100%<br>Нэгжийн даргын үнэлгээ: 100%<br>Нэгжийн даргын үнэлгээ төлөвлөсөн хугацаандаа гүйцэтгэсэн |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | 154 арга хэмжээ төлөвлөгдсөнөөс Бүрэн хэрэгжсэн буюу 100%-тай 115, 90%-тай 33, Хэрэгжих шатанд буюу 70%-тай 4, 50%-тай-2 арга хэмжээ тус тус үнэлэгдэж, үнэлгээний дундаж хувь 96,43%-тай гарсан болно. Байгууллагын ил тод байдлыг шалгуур үзүүлэлтийн хэрэгжилт 100%-тай үнэлэгдсэн. Мөн Төрийн албан хаагчийн сургалт, нийгмийн баталгаа, ажиллах нөхцөлийг хангах хөтөлбөр 100%-ийн хэрэгжилттэй үнэлэгдлээ.<br>Хавсралт: 1 файл | | байдал: 100% |
| 4 | Боловсролын ухааны сайдын аймаг, нийслэлийн Засаг дарга нартай байгуулсан үр дүнгийн гэрээнд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх. | Зорилтын тоо, шалгуур | Боловсрол, шинжлэх ухааны сайдын аймаг, нийслэлийн Засаг дарга нартай байгуулсан үр дүнгийн гэрээнд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн 2024 оны жилийн эцсийн тайлан | Тайланд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, зөвлөмжийг хүргүүлсэн байна. | Боловрролын сайдын Аймаг, нийслэлийн засаг даргатай 2024 онд боловсролын салбарт хамтран ажиллахаар байгуулсан гэрээний хэрэгжилтэд 2025 оны 02 сарын 21-ээс 02 сарын 28-ны хооронд хяналт шинжилгээ, үнэлгээ хийж, Засгийн газрын үнэлгээний системд оруулж ажилласан. | 1-р сар, 6-р сар | Өөрийн үнэлгээ: 100%<br>Нэгжийн даргын үнэлгээ: 90%<br>Нэгжийн даргын үнэлгээ төлөвлөсөн хугацаандаа гүйцэтгэсэн байдал: 50% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 5 | Гүйцэтгэл, үр дүнд суурилсан санхүүжилтийн хэрэгжилтэд холбогдох нэгжүүдтэй хамтран хяналт-шинжилгээ, үнэлгээ, аудит хийсэн байна. | Хамрагдах байгууллагын тоо | - | Хяналт-шинжилгээ, үнэлгээ, аудитыг хийж, цаашид хэрэгжүүлэх арга хэмжээний санал зөвлөмжийг боловсруулсан байна. | Тухайн арга хэмжээг 8, 9, 10 дугаар саруудад зохион байгуулахаар төлөвлөсөн. Харин 9 сард хийгдэхээр төлөвлөсөн байсан "Ерөнхий боловсролын сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээг дэмжих үндэсний хөтөлбөр"-ийн хэрэгжилтэд хяналт шинжилгээ, дотоод аудит хийх ажлын 3, 4-р сард хийж гүйцэтгэсэн. Боловсролын сайдын 2025 оны 02 сарын 21-ний өдрийн А/89 дүгээр тушаалаар "Ерөнхий боловсролын сургуулийн хоол үйлдвэрлэл үйлчилгээг дэмжих үндэсний хөтөлбөр "-ийн хэрэгжилт, үр дүнд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, дүгнэлт зөвлөмж гаргах ажлын хэсэг байгуулагдсан. Тус ажлын хэсэгт нарийн бичгийн даргаар томилогдон ажилласан. Хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, дүгнэлт, зөвлөмж гаргах ажил дуусч, нэгдсэн тайлан, танилцуулгыг эцэслээд байна. | 4-р сар, 5-р сар, 6-р сар | Өөрийн үнэлгээ: 100%<br><br>Нэгжийн даргын үнэлгээ: 100%<br><br>Нэгжийн даргын үнэлгээ төлөвлөсөн хугацаандаа гүйцэтгэсэн байдал: 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | Хавсралт: 1 файл | | |
| 6 | Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн биелэлтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж тайлагнах. | Зорилтын тоо, шалгуур | Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн биелэлтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн 2024 оны хагас, бүтэн жилийн тайлан | Хяналт-шинжилгээ, үнэлгээний тайлангийн үр дүнгээр гарсан зөвлөмжийн биелэлтийг хангуулж ажилласан байна. | Засгийн газрын үйл ажиллагааны 2020-2024 оны хөтөлбөрийн хэрэгжилтийг 2024 оны хагас жилийн байдлаар үнэлгээ хийж, тайлагнасан. Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд Боловсрол, шинжлэх ухааны салбарын чиглэлээр тусгагдсан зорилт арга хэмжээний 2024 оны эхний хагас жилийн биелэлтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхэд 91,15%-ийн гүйцэтгэлтэй байна. Төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээг тодорхой үр дүнтэй хэрэгжүүлснээр боловсрол, шинжлэх ухааны яамны 2024 оны эхний хагас жилийн төлөвлөгөөний хэрэгжилт 91,15%-ийн гүйцэтгэлтэй үнэлэгдсэнийг 2023 оны эхний хагас жилийн гүйцэтгэлтэй | 1-р сар, 12-р сар | Өөрийн үнэлгээ: 100%<br>Нэгжийн даргын үнэлгээ: 90%<br>Нэгжийн даргын үнэлгээ төлөвлөсөн хугацаандаа гүйцэтгэсэн байдал: 50% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | харьцуулахад 12,52%-иар өссөн үзүүлэлттэй байна. Засгийн газрын 2024-2028 оны мөрийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөө 2025 оны 04 сард батлагдсан. 2025 оны эхний хагас жилийн байдлаар тайланд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийгдэнэ.<br>Хавсралт: 1 файл | | |
| 1.2. Төрийн захиргааны төв байгууллагын болон харьяа байгууллагын хүний нөөцийн удирдлагын бодлого, төлөвлөлт, хэрэгжилтийг хангах, эрх зүйн зөвлөгөө, дэмжлэг үзүүлэх, мэдээллийн ил тод байдлыг ханган ажиллана. | | | | | | | |
| 7 | Яаманд иргэдээс ирүүлсэн өргөдөл гомдлын шийдвэрлэлтийн байдалд хяналт шалгалт хийж, зөвлөмж хүргүүлнэ. | Хэрэгжилтийн хувь | - | Иргэдээс ирүүлсэн өргөдөл гомдлын шийдвэрлэлтэд хяналт тавьж ажилласан байна. | Яаманд иргэдээс ирүүлсэн өргөдөл гомдлын шийдвэрлэлтийн байдалд хяналт шалгалт хийж, зөвлөмж хүргүүлэх ажлыг 06 сард багтаан зохион байгуулахаар төлөвлөсөн. Өнөөдрийн байдлаар тус ажлын хүрээнд ТЗУГ-ын холбогдох мэргэжилтэнд албан мэйлээр мэдээлэл ирүүлэх тухай хүсэлт хүргүүлээд байна. Өргөдөл гомдлын шийдвэрлэлтийн мэдээлэл нэгтгэгдэж ирсэн өдрөөс 14 хоногт багтаан хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, дүгнэлт зөвлөмж | 6-р сар | Өөрийн үнэлгээ: 50%<br>Нэгжийн даргын үнэлгээ: 70%<br>Нэгжийн даргын үнэлгээ төлөвлөсөн хугацаандаа гүйцэтгэсэн байдал: 50% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | гаргаж, удирдлагад танилцуулах юм. | | |
| 8 | Баянзүрх дүүргийн Боловсролын хэлтсийн үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудит хийх. | Үйл ажиллагааны төлөвлөгөөний гүйцэтгэлийн чанар, үр дүн | - | Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудит хийх удирдамжийг боловсруулан ажлыг эхлүүлсэн байна. | Тус ажлыг 8, 9, 10 дугаар сард зохион байгуулахаар төлөвлөсөн. ТАЗ-ийн даргын 2025 оны 01 сарын 17-ны өдрийн 02 дугаар тушаалаар батлагдсан ажлын хэсгийн бүрэлдэхүүнд томилогдож, 2025 оны 03 сарын 16- аас 04 сарын 02-ны хооронд Архангай, Завхан аймгийн 16 сумдын төрийн байгууллагууд Төрийн албаны тухай хууль болон холбогдох бусад хуулиар хүлээсэн чиг үүргээ хэрэгжүүлж буй байдал, хүний нөөцийн зохицуулалттай газар дээр нь танилцаж хяналт шалгалт хийх, зөвлөгөө зөвлөмж өгч, зөвлөн туслах байдлаар ажиллаа. Тус ажлын хэсгийн хүрээнд сумдын сургууль, цэцэрлэг, ЭМТ, соёлын төвийг хариуцан холбогдох материалуудтай танилцаж, үзлэг шалгалт хийж, зөрчил дутагдалд тухай бүр нь зөвлөгөө зөвлөмж өгч, нэгдсэн тайлан боловсруулж, | 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 9-р сар, 10-р сар | Өөрийн үнэлгээ: 100%<br>Нэгжийн даргын үнэлгээ: 100%<br>Нэгжийн даргын үнэлгээ төлөвлөсөн хугацаандаа гүйцэтгэсэн байдал: 50% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | ТАЗ-д хүргүүлсэн болно. Нийтлэг илэрсэн зөрчлөөс дурдвал: 1. Байгууллагуудын хүний нөөцийн систем хөтлөлт дутуу, нийтлэгээр зарим албан хаагчдын боловсролын мэдээлэл оруулаагүй, бусад цэсүүдийг бүрэн хөтлөөгүй байна. 2. Хувийн хэрэгт ажилд томилогдсон чөлөөлөгдсөн тушаал дутуу, хавсаргаагүй, 600 дугаар тогтоолын дагуу бүрдүүлээгүй зэрэг алдаатай. 3. Тушаалын үндэслэл буруу, бичиг үсгийн алдаатай зөрчил илэрсэн. 4. Барилга байгууламж харилцан адилгүй, их засвар, шинэ барилга зайлшгүй шаардлалагатай сургууль, цэцэрлэгүүд байна. Мөн байгууллагын удирдлагын зохион байгуулалтаас хамаарах асуудал цөөнгүй байна. 5. Соёлын төвд мэргэжлийн бус хүн томилох зөрчил нийтлэг байна. 6. Эмнэлгийн дарга албан тушаалын | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | шаардлага хангаагүй, шалгалт өгөөгүй томилогдсон зөрчил байна.<br>7. Сургуульд Хими, Физик, Гадаад хэл, Математикийн багш , цэцэрлэгч эмч, арга зүйч дутагдалтай байгаа бол эмнэлэгт дийлэнхдээ Эх баригч эмч, Их эмч, Багийн эмч дутагдалтай байна.<br>Хавсралт: 2 файл | | |
| 9 | Насан туршийн боловсролын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх /Төвийн бүс-Баянгол, Хан-Уул дүүрэг, Дархан-Уул, Сэлэнгэ, Орхон, Төв аймаг/ | Үйл ажиллагааны төлөвлөгөөний гүйцэтгэлийн чанар, үр дүн | - | Хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх удирдамжийг боловсруулж ажлыг эхлүүлсэн байна. | Насан туршийн боловсролын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх /Төвийн бүс-Баянгол, Хан-Уул дүүрэг, Дархан-Уул, Сэлэнгэ, Орхон, Төв аймаг/ ажлыг ХШҮДАГ-ын дарга солигдсон зэрэг тодорхой шалтгааны улмаас 8, 9, 10, 11 дүгээр саруудад хийж гүйцэтгэхээр төлөвлөөд байна. Боловсролын сайдын 04 сарын 08-ны өдрийн А/147 дугаар тушаалаарб батлагдсан "Докторын зэрэг хамгаалуулах зөвлөлийн дүрмийн талаар хяналт шалгалтын байгууллагаас ирүүлсэн | 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар | Өөрийн үнэлгээ: 100%<br>Нэгжийн даргын үнэлгээ: 100%<br>Нэгжийн даргын үнэлгээ төлөвлөсөн хугацаандаа гүйцэтгэсэн байдал: 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | дүгнэлтийг судлах, хариу тайлбар бэлтгэх" ажлын хэсгийн бүрэлдэхүүнд гишүүнээр ажиллаж байна. Тус ажлын хэсгийн хүрээнд ТНБД-ын удирдамж батлагдсан. Удирдамжид "Докторын зэрэг хамгаалуулах зөвлөлийн дүрмийн талаар хяналт шалгалтын байгууллагаас ирүүлсэн дүгнэлтийг судлах хариу тайлбар бэлтгэх" гишүүдийг томилсон. Ахлагчаар Г.Энхтөр, гишүүдээр Д.Батдорж, Г.Наранбаатар, Т.Ариунболд, Д.Баттогтох нар ажиллаж, хариу тайлбар бүхий албан бичгийн төслийг боловсруулсан. Хавсралт: 2 файл | | |
| 10 | Цэцэрлэг, сургуулийн нүхэн жорлонг орчин үеийн ариун цэврийн байгууламжаар солих үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх | Ашиглалтад орсон байгууламжийн тоо | 2024 оны гүйцэтгэл | Хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх ажлыг эхлүүлсэн байна. | Цэцэрлэг, сургууль, дотуур байрын нүхэн жорлонг ариун цэврийн байгууламжаар солих үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, дүгнэлт, зөвлөмж гаргах ажил үе шаттайгаар /03-11 сарын хооронд/ хийгдэж байна. 2025 оны 3 дугаар сард | 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар | Өөрийн үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ төлөвлөсөн хугацаандаа |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | Завхан, Архангай аймгийн нийт 16 сумдаар ТАЗ-өөс санаачилсан төрийн байгууллагын үйл ажиллагаатай танилцах, шалгах, зөвлөгөө зөвлөмж өгөх зорилго бүхий ажлын хэсгийн бүрэлдэхүүнд ажилласан. Тус ажлын үеэр тухайн сумдуудын цэцэрлэг, сургууль, дотуур байрын нүхэн жорлонг ариун цэврийн байгууламжаар солих ажлын явц байдал, ашиглалттай танилцаж, газар дээр нь зөвлөгөө зөвлөмж өгч, тулгамдаж байгаа асуудлыг холбогдох нэгж байгууллагад уламжилж ажилласан. Сумдын сургууль, цэцэрлэг, дотуур байрны ариун цэврийн байгууламжтай холбоотой өгсөн зөвлөмжийн хүрээнд Завхан аймгийн Их-Уул, Баянтэс, Яруу сумдаас эргэж холбогдож тулгамдаж байгаа асуудлын талаар мэдээлэл өгсөн. БЕГ болон барилгын хөгжлийн төвийн холбогдох инженерүүдтэй холбож | | гүйцэтгэсэн байдал: 50% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | өгч, асуудлыг шийдвэрлүүлж ажилласан. 2025 оны 11 сар гэхэд нийтдээ 3-4 аймгийн хэмжээнд нүхэн жорлонг ариун цэврийн байгууламжаар солих ажлыг газар дээр нь танилцаж зөвлөгөө өгч, нэгдсэн тайлан дүгнэлт боловсруулж, удирдлагад танилцуулахаар төлөвлөөд байна.<br>Хавсралт: 18 файл | | |
| 11 | Сургуулийн өмнөх боловсролын хувилбарт сургалтын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх | - | - | Хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх ажлыг удирдамж боловсруулсан байна. | ХШҮДАГ-ын дарга солигдсон зэрэг шалтгааны улмаас ус ажлыг 8, 9, 10, 11 дүгээр саруудад зохион байгуулахаар төлөвлөсөн. Боловсролын сайдын 2025 оны 04 сарын 09-ний өдрийн "Удирдамж батлах тухай" А/149 дугаар тушаал, ТНБД-ын ажлын хэсэг байгуулх тухай 2025 оны 05 сарын 08-ны өдрийн "Ажлын хэсэг байгуулах тухай" А/107 дугаар тушаалуудаар БҮТ-ийн үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудит хийх ажлын хэсэг, | 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар | Өөрийн үнэлгээ: 100%<br>Нэгжийн даргын үнэлгээ: 90%<br>Нэгжийн даргын үнэлгээ төлөвлөсөн хугацаандаа гүйцэтгэсэн байдал: 50% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | удирдамж батлагдсан. Ажлын хэсгийг СХГ-ын дарга Л.Төгсбаяр дарга ахалж, гишүүдээр Д.Батдорж, Б.Ариунтуяа, О.Баярсүрэн, С.Пүрэвсайхан, нарийн бичгийн даргаар Ц.Нямсүрэн нар ажиллаж байна. Одоогийн байдлаар холбогдох тайлан мэдээллийг гаргуулан авч танилцах, тодруулга, нэмэлт мэдээлэл авах ажлууд хийгдэж байна. | | |
| 12 | Нийслэлд үйл ажиллагаа явуулж буй төрийн өмчийн цэцэрлэгийн хоолны зардлын гүйцэтгэлд хяналт-шинжилгээ, дотоод аудитыг хийж, цаашид хэрэгжүүлэх арга хэмжээний санал дүгнэлт боловсруулах | - | - | Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитыг хийх ажлын удирдамж боловсруулсан байна. | Тус ажлын хүрээнд Чингэлтэй дүүргийн 280, 103 дугаар цэцэрлэгүүдэд ажиллаж, хоолны зардал, бүртгэл, эцэг эхийн хяналтын системийн ашиглалттай танилцсан. Тус ажлыг 3-11 сарууддад үе шаттай хийж хэрэгжүүлэх юм. Хэрэгжилтийг тооцох хугацаа болоогүй байна. | 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар | Өөрийн үнэлгээ: 100%<br>Нэгжийн даргын үнэлгээ: 70%<br>Нэгжийн даргын үнэлгээ төлөвлөсөн хугацаандаа гүйцэтгэсэн байдал: 50% |

НЭМЭЛТ АЖЛЫН БИЕЛЭЛТ

| № | Үүрэг даалгавар | Өгсөн субьект | Биелэлт |
|---|---|---|---|
| 1 | 2 | 3 | 4 |

ХОЁР. МЭДЛЭГ ЧАДВАРАА ДЭЭШЛҮҮЛЭХ ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭНИЙ БИЕЛЭЛТ

| № | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Гүйцэтгэлийн түвшин | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин / биелэлт | Эхэлсэн, дууссан хугаца | Биелэлтийн хувь |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| 4.1. Төрийн албаны тухай хууль, салбарын хууль, дагалдан гарсан хууль тогтоомжид заасан мэдлэг чадварыг эзэмших, тасралтгүй хөгжүүлэх | | | | | | | |
| 1 | Төрийн албаны тухай хууль, салбарын хууль, дагалдан гарсан хууль тогтоомжийг тогтмол судалж, ажил үүрэгтэй ашиглах. | - | - | - | Төрийн албаны тухай хууль, салбарын дагалдан гарсан хууль тогтоомжийг тогтмол судалж, өдөр тутмын үйл ажиллагаандаа ашиглаж байна. Боловсролын багц хууль батлагдан гарсантай холбогдуулан Засгийн газар, Яам дангаар болон бусад яамтай хамтрай батлах дүрэм, журам, стандартын хэрэгжилтийн явцын талаар мэдээллийг бэлтгэж удирдлагад танилцуулсан. | 1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар | Өөрийн үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ: 100% |
| 2 | Хяналт-шинжилгээ, үнэлгээний чиглэлээр сургалтад хамрагдана. | Хяналт-шинжилгээ, үнэлгээний чиглэлээр сургалтад хамрагдана. | - | Хяналт-шинжилгээ, үнэлгээний чиглэлээр сургалтад хамрагдсан байна. | "УИХ-ын Тамгын газраас зохион байгуулж буй “ҮР ДҮНД СУУРИЛСАН ҮНЭЛГЭЭ, МОНИТОРИНГИЙН ТОГТОЛЦОО БҮРДҮҮЛЭХ НЬ” сэдэвт хэлэлцүүлэгт 2025 оны 05 сарын 16-ны өдөр оролцлоо. Тус хэлэлцүүлгээр УИХ-ын гишүүд, яамдууд болон холбогдох бусад байгууллагын төллөөлүүд оролцож, өмнөх оны тайлан, үнэлгээ, цаашид мониторингийг хэрхэн хийх вэ, үр дүнг хэрхэн тооцох вэ, хэрхэн төлөвлөх вэ зэрэг сургалт, илтгэлүүдийг тавьж, санал солилцлоо. Мөн Боловсролын яамнаас тогтмол зохион байгуулдаг мэдээллийн цагт тухай бүр нь | 4-р сар, 10-р сар | Өөрийн үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ: 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | хамрагдаж, холбогдох мэдээ мэдээллийг авч байна.<br>Хавсралт: 2 файл | | |

ТАЙЛАН ГАРГАСАН:

Мэргэжлийн болон сургуулийн өмнөх боловсролын байгууллагын хяналт шинжилгээ, үнэлгээ хариуцсан ахлах мэргэжилтэн, Д Батдорж /................................................./ Огноо: .........................